

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гаргаж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээр явцын үнэлгээ хийлгэж дүгнүүлсэн.

Мөн Бодлогын баримт бичгүүдийн 2020 оны эхний хагас жилийн биелэлтийг холбогдох хэлтэс, агентлагуудаас авч нэгтгэж байна.

Аймгийн Онцгой комисс 7-р сарын 1-ний өдөр хуралдаж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдүүдийг ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг 2020 оны 7 дугаар сарын 15-ыг дуустал сунгах, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархалт буурахгүй байгаатай холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан, спортын үйл ажиллагаа, цахим тоглоомын газар, диско болон бүжгийн баарны үйл ажиллагаа явуулахыг түр хугацаагаар хориглох, Бүх төрлийн тоглоомын газар, баар, караоке, биллиард, шашны байгууллага /сүм, хийд, мөргөлийн газрууд/ соёл урлаг, үзвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээх, Хурим найр хийдэг үйлчилгээний газруудын үйл ажиллагааг 2020 оны 07 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн нээж Эрүүл мэндийн яамнаас гарсан зөвлөмжийг баримтлан бага насны хүүхдийг тухайн газарт оруулахгүй, бүжиг зохион байгуулахгүй байх арга хэмжээг авч халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэхэд хяналт тавьж ажиллах зэрэг шийдвэрүүдийг гаргав.

Уг шийдвэртэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн "Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай А/499 тоот захирамж гарсан болно.

1.1.1. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

Нийт 2852 өргөдөл ирүүлснээс:

-Хүсэлт	2745 /96.2%
-Гомдол	107 /3.7%
-Ажил эрхлэлттэй холбоотой	759 /26.6%
-Газрын харилцаатай холбоотой	667 /23.4%
-Нийгмийн халамж, үйлчилгээтэй холбоотой	187 /6.6%
-Эд материал, орон байр, санхүүгийн дэмжлэг хүссэн	148 /5.2%
-Иргэний бүртгэл мэдээлэлтэй холбоотой	136 /4.7%

ХОЁР. ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.Хөдөө аж ахуйн чиглэлээр

Энэ оны 6 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт төллөх 910416 хээлтэгчээс 94,8% нь төллөж, гарсан төлөөс 7018 төл хорогдсон. Гарсан төлийн 99,19% нь эсэн мэнд бойжсон мэдээтэй байна.

Оны эхний малаас 3686 толгой мал зүй бусаар хорогдож малын онд оролт 99,8%-тай байна. Мал аж ахуйн өвөлжилт хэвийн явагдаж байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс ирсэн мэргэжилтэн аймгийн ХХААГ-ын мэргэжилтэнтэй хамт бүх сумдын нутгаар явж царцааны тархалтын судалгаа хийсэн. Судалгааг үндэслэн аймгийн Засаг даргын 2020 оны А/441 захирамжаар Толбо, Алтай, Буянт, Сагсай сумдын 20000 га талбайд царцаатай тэмцэх хуваарь гарсан ба уг ажлыг 6-р сарын 18-ны өдрөөс эхлүүлсэн.

5 төрлийн халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 13 сумын нийт 1109900 толгой малыг хамруулахаар шаардагдах вакцины тоо хэмжээ, үнэ, үйлчилгээний хөлсийг тооцож гарган Биокомбинат Улсын төсөвт үйлдвэрийн газартай вакцин худалдан авах гэрээ хийсэн. Энэхүү 5 төрлийн халдварт өвчнөөс 1109900 толгой малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахад 233,829,000. төгрөгийн вакциныг худалдан авахаар Биокомбинат УТҮГ-тай гэрээ хийсэн ба одоогийн байдлаар 5 төрлийн вакциныг гэрээний дагуу хугацаанд нь нийлүүлж, 13 сумын 623785 толгой малыг тарилгад хамруулсан. Одоогоор вакцинжуулалт төлөвлөгөөний дагуу 57.6 хувьтай явж байна.

2020 оны тариалалтын бэлтгэл ажил хангуулах тухай аймгийн Засаг даргын А/124 тоот захирамж гарч сум тус бүрт 2020 онд тариалах талбай, хураах ургацын төлөвлөгөө өгөгдсөн. 6-р сарын 19-ний өдрийн мэдээгээр 15 га-д үр тариа, 306,1 га-д төмс, 144,4 га-д хүнсний ногоо, 94,1 га-д жимс, жимсгэнэ, 693 га-д малын тэжээл, нийт 1237,9 га-д тариалалт хийгээд байна.

Дэлхий даяар коронавирусийн өвчин гарсантай холбогдуулан аймгийн ХХААГазар болон МЭ-ийн газраас аймгийн бүх сонгуулийн хэсэг, санал авах байруудад ариутгал, халдваргүйжүүлэлтийг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэсэн.

Коронавирус болон томуу, томуу төст өвчний дэгдэлтийн улмаас улс даяар онц байдал тогтоож байгаатай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/167 тоот захирамжаар ажлыг хэсэг байгуулан орон нутгийн хүнсний нөөцийн судалгааг өдөр бүр гаргаж аймгийн Онцгой комисс, ХХААХҮЯамд хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд бог малын хээлтүүлэгчийг ялгах, ангилалт, үзлэгт хамааруулах, шинээр хээлтүүлэгч бойжуулах мэргэжлийн ажлын хэсгийг аймгийн ХХААГ-ын даргаар ахлуулан байгуулж ажлыг хэрэгжүүлэв.

Аймгийн ЖДҮДСанд 2020 онд 1 тэрбум төгрөгний эх үүсвэр хуваарилагдсантай холбогдуулан ХХААХҮЯ-аас баталсан 9 салбар чиглэлээр төсөл хүлээж авахаар зар мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллээр зарласан. Төслийг заасан хугацаанд аймгийн ХХААГазарт хүлээж авсан болно. Нийт 3,8 тэрбум төгрөгний 39 төсөл хүлээн авч ХААДСанд явуулсан. Төсөл шалгаруулах дэд хороог ЗДТГ-ын даргаар ахлуулан шинэчлэн байгуулсан.

СХЗХ-ийн Хэмжүүрийн улсын шалгагч нар Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа 100 гаруй худалдаа, үйлчилгээний газруудад баталгаажуулалтын шалгалт хийж MNS 5021-1:2019 стандартын шаардлага хангасан эсэхэд болон савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хяналт-шалгалтыг хийж гүйцэтгэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын үйлчилгээний чанарыг сайжруулах ажлын чиглэлийн хүрээнд Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, дэн буудал, зоогийн газруудад холбогдох хууль, тогтоол, стандартыг таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид стандартыг мөрдүүлэх зорилгоор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газартай хамтран хяналт-шалгалт хийсэн.

СХЗХ-ээс эхний 6 сард 520 ш цахилгаан тоолуурын баталгаажуулалт хийж, 3469,0 мянган төгрөг, даралтын хэмжлийн төрлөөр 50 ш даралтын хэмжих хэрэгсэлд баталгаажуулалтын гэрчилгээ олгож 250,0 мянган төгрөг, хүндийн хэмжлээр 208 ш хэмжих хэрэгсэл баталгаажуулж, 2465,0 мянган төгрөг, эзлэхүүн зарцуулалт 257 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт, шалгалт тохируулгын гэрчилгээ олгож төсөвт 2790,0 мянган төгрөг, нийт 1035 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийж, нийт 8974,0 мянган төгрөгийн орлого орууллаа.

Үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ MNS 5012:2011, Улс хоорондын зорчигч тээвэрлэлт MNS 5831:2007 стандартуудыг сурталчлан сургалт явуулж, ЗГ-ын 2018 оны 291 дугаар тогтоол болон стандартын дагуу тохирлын үнэлгээнд хамруулж гэрчилгээ олгов.

Эхний хагас жилд: 49 ААН-тэй тохирлын гэрчилгээ хэрэглэх гэрээ байгуулсан.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

5.1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр

Тухайн жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас эрх нь шилжин хэрэгжих 19654,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн. 6 дугаар сарын байдлаар шинээр хэрэгжих 7717,4 төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 4167,6 сая төгрөгийн гэрээ байгуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60 хувьтай байна. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд нийт 105 төсөл арга хэмжээ төлөвлөгдөж 2020 онд 4428,4 сая төгрөг санхүүжигдэхээр батлагдсан юм. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний хэрэгжилт 70 хувьтай байна. Эхний хагас жилийн байдлын гүйцэтгэлээр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс нийт 1116,6 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

5.2. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн ГХБХБГазартай хамтран Бугат, Толбо сумын нутаг дэвсгэрт байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн хариуцан хамгаалж буй газар нутгийн хил хязгаарыг зурагжуулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулав.

6 иргэн аж ахуйн нэгжийн төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж хүргүүлэв. “Байгалиа хамгаалъя” сарын аяны хүрээнд хийсэн ажлын тайланг яаманд хүргүүллээ.

Харнуур-Ховд голын сав газрын захиргаатай хамтран холбогдох байгууллагуудад Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулав.

Ус бохирдуулсны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль тогтоомжуудыг орон нутгийн радиогоор сурталчлах ажлыг зохион байгууллаа.

Өлгий сумын 13 дугаар багийн “Жайнаш” Халуун усны газарт 2020 оны ус ашиглуулах дүгнэлт гаргаж хүргүүлэв.

"Зөв дадал, ногоон ирээдүй, нийгмийн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй байгууллага-2020" чөлленж өрнүүлсэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын удирдамжийн дагуу 5 дугаар сарын 6-ны Дэлхийн байгаль хамгаалах өдрийг угтаж Өлгий сумын 11-дүгээр баг буюу Ховд голын эрэг дагуу цэвэрлэгээний ажил хийж, Монгол Алтайн нурууны болон Хөх Сэрхийн нурууны улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаад, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар зэрэг албан байгууллагууд Өлгий сумын Ховд гол, Дэлүүн сумын Дэлүүн, Ганц модны голын дагуух эзэнгүй хур хог ихтэй газарт цэвэрлэгээ хийж, дараагийн байгууллагыг уриалах ажлыг зохион байгуулав.

“БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН САНААЧЛАГА” ТББайгуулагатай хамтран Алтай, Алтанцөгц, Баяннуур, Сагсай, Булган, Дэлүүн, Цэнгэл, Ногооннуур сумдад Ойн хөнөөлт шавжийн экологи, биологийн онцлог, тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбай сонгох ажлыг гүйцэтгэв.

Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ төрлийн Коронавирус /COVID-19/ халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зочид буудал, амралт, сувиллын газар, жуулчны баазуудад аймгийн Засаг даргын 2020 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн “Зочид буудал, амралт, сувиллын газар, жуулчны баазын үйл ажиллагаанд мөрдөх тусгай горим батлах тухай” А/421 тоот захирамжийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Усны тухай хуулийн 27.1-т заасны дагуу Өлгий сумын 4-р багт байршилтай НИК ХХК-ийн Баян-Өлгий аймаг дахь нефть хангамжийн салбарын унд ахуйн зориулалтаар нэг цооног өрөмдөх хүсэлтийн дагуу цооног өрөмдөх зөвшөөрөл олгов.

Толбо сумын Байгаль хамгаалагч нарын ажилтай танилцаж, заавар зөвлөгөө өгч, тус сумдын ард иргэдэд байгаль орчныг хамгаалах багц хуулиуд болон аймгаас батлагдсан хог хаягдлын дэд хөтөлбөр, захирамжуудын хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар заавар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 2021 онд ойн сангаас бэлтгэх түлээний модны хэмжээ, ойн дагалт баялгийн цэцэглэлтийн судалгааг эхний хагас жилийн байдлаар бэлтгэсэн модны гүйцэтгэлийн судалгааг гаргаж БОАЖЯамны Ойн судалгаа, хөгжлийн төвт, Өлгий сумын “Жадыра” халуун усны газрын 2020 оны ус ашиглуулах дүгнэлт гаргаж хүргүүлэв.

5.3. Газрын харилцааны чиглэлээр

Урд өмчлүүлсэн газрын хэмжээ болон багийн дугаарыг засварлаж 8 иргэнд 5251 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх, нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 32 иргэнд 24897 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар, аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй газраа өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 2 иргэнд 1150м2 газрыг 17250000 төгрөгөөр

давуу эрхээр үнээр нь худалдаж өмчлүүлсэн гэгддэг үзүүлэлтүүд бусдад шилжүүлж газар эзэмшүүлэх дараа шийдвэр гарсан.

430 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгэв.

Аймгийн хэмжээнд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаж батлагдсан нийт 63 нэгж талбар дээр газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг сумдын Засаг даргын 4 удаагийн захирамжаар, аймгийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар тус тус газрын цахим биржээр дамжуулан 6 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулагдаж орон нутгийн төсөвт 39,2 сая төгрөг төвлөрүүлсэн.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан 2020 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1271 нэгж талбарыг Газар зохион байгуулалтын системд оруулсан.

5.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:

Төвийн вэб сайтад холбогдох мэдээ, мэдээллийг байршуулав.

Аймгийн ЗДТГазрын 3-02/459 дүгээр албан тоотын дагуу шуурхай штабын байранд заасан хугацаанд жижүүрийн үүрэг гүйцэтгэв.

АЗДТГазарт үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратеги судалгаа, байгууллагын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлэв.

Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээ хийх зааврын дагуу аймаг, сумдын ой хээрийн гал түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж ОБГазарт хүргүүлэв.

Мөстөл судлалын станц Алтай Таван Богд дахь судалгааны ажлыг эхлүүлэв.

5.5. Уул уурхайн чиглэлээр

Ногооннуур сумын “Тавалтайн ам” нэртэй талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан “Металлкен” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл аваад үлдсэн 34 га талбайн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан тул уг аж ахуйн нэгжийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

“МЖЛ-Алтай” ХХК-ийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасныг хянан үзэж уул уурхайн кадастрын системийн программаар бүртгүүлсэн.

5.6. Дэд бүтцийн чиглэлээр

5.6.1. Цахилгаан хангамжийн талаар

Аймгийн хэмжээнд Баруун бүсийн эрчим хүчний системээс 21897.0 мян.кВ.цаг цахилгааныг худалдан авч, 18805.0 мян.кВ.цаг цахилгаан худалдан борлуулсан. Нийт 3092.0 мян.кВ.цаг цахилгааныг шугамд алдсан. Нийт алдагдал 14.1%-тай байгаа. Худалдан борлуулсан цахилгаанд 2856.0 сая төгрөгийн нэхэмжлэл бичиж, 2781.0 сая төгрөгийг цуглуулсан. Борлуулалтын орлого 97,0%-ийн цуглуулгатай байна.

5.6.2. Мэдээлэл холбоо сүлжээний газрын мэдээлэл

Компаниас олгосон дулаан мэдрэгч хэмжүүрээр өдөр бүр өглөө бүх ажилтнуудын халууныг хэмжин, эрүүл мэндэд хяналт тавьж ажиллаж байна.

Гүйцэтгэх захирлын 2020 оны А/34 тоот тушаалын дагуу 12 нас хүртэл хүүхэдтэй эмэгтэй ажилтнуудыг ажлаас чөлөөлж ажлыг нь зохицуулан гүйцэтгүүлж байна.

Газар нь 2020 оны 6 дугаар сард шуудангаар болон мэйл хаягаар компаниас 3, орон нутгийн бусад байгууллагаас 4, нийт 7 албан бичиг хүлээж авч тухай бүр бүртгэл хөтлөн, байгууллагын удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтнуудад шилжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Мөн газрын үйл ажиллагааны асуудлаар албан байгууллагад 4 албан бичиг боловсруулан хүргүүлж хариу, шийдвэр гаргуулж ажиллав.

Улс, хот хоорондын сүлжээний бэлэн байдлыг хангаж, орон нутгийн иргэд, албан байгууллагууд мэдээ, мэдээллийг цаг тухай бүр, шуурхай хүлээж авах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд онцгой анхаарч аймаг, сумын шилэн кабель, кабель шугамын үзлэг, үйлчилгээг тогтмол чанартай хийж, гарсан гэмтэл саатлыг шуурхай илрүүлэн засч, зөрчлийг арилгах арга хэмжээг байнга авч ажилласны дүнд сүлжээнд саатал гараагүй болно. Тайлант сард үндсэн SDH төхөөрөмжөөс гэмтэл саатал гараагүй.

Энэ сард нийт 14,173.68 мянган төгрөгийн орлого олохоос 15,977,60 мянган төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөөг 13 хувиар давуулан биелүүлэн гүйцэтгэсэн.

5.6.3. Аймгийн радио телевизийн сүлжээний ажлын талаар

Аймгийн радио болон тоон телевизийн станцуудын ажиллагаанд хяналт тавьж гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлаж, өдөр бүр үзлэг үйлчилгээ хийсэн. Мөн сум, орон нутгийн тоон телевизийн тоног төхөөрөмжүүд гэмтсэн үед тухай бүр засварласан. Цахилгаан щит, автоматуудад үзлэг үйлчилгээ хийсэн болно.

5.6.4. Усны талаар

Өлгий сумын хэмжээнд “Галын гидрантыг усаар хангах зориулалттай галын далд усны цэгт хяналт-шалгалт хийж, судалгаа гаргах” нэгдсэн арга хэмжээ зохион явуулах ажлын удирдамжийн дагуу тус компанийн зүгээс хийж гүйцэтгэсэн тайлан мэдээ, тооцоо судалгааг гаргаж албан тоотоор хүргүүлсэн.

Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүдийг нийт 8 газарт зохих журмын дагуу техникийн нөхцөл олгож, цэвэр усны шугамд холбосон.

Цэвэр усны өргөх станцын гүний 2-р хуучин насосыг шинээр сольж, хэрэглэгчдийг найдвартай ундны усаар хангах ажлыг зохион байгуулав.

Айл өрх, орон сууцны хэрэглэгчдээс дотор болон гадна цэвэр, бохир усны шугамын гэмтлийн дуудлагуудыг хүлээн авч цаг тухайд засаж, ажиллагааг хэвийн болгон ажилласан.

5.6.5. Авто тээврийн чиглэлээр

Эхний 6 сарын байдлаар өссөн дүнгээр техникийн хяналтын үзлэгт нийт 4488 тээврийн хэрэгсэл хамрагдав. Үүнд суудлын тэрэг 2761, ачааны тэрэг 818, автобус 344, тусгай 23, механизм 4, зүтгүүр 15, чиргүүл 15, Мотоцикл 492, Цистерн 16 тус тус хамрагдсан.

Өлгий-Улаанбаатарын чиглэлд 6-р сард нийт 35 рейсээр 1465 зорчигчийг тээвэрлэсэн.

Өдөр бүр орон нутгийн зорчигчдын тээврийн хэрэгсэлд хяналт тавьж бүртгэл гарган ажиллав.

Энэ сард улс хоорондын зорчигч тээвэрлэлт яваагүй.

5.6.6. Нисэх буудлын үйл ажиллагааны талаар

2020 ийү 5 дугаар 14-нөөн 6 дугаар сарын 30-ныг өгсөөр нийт 18 агаарын тээврийн хэрэгсэл 168 удаа 20, 11, 253 ш, гар тээш 226 ш, 7ш шуудан “Азийн-Төвийн” ОХУ-ийн 10 дахин 257 удаа 11, 17, 354 ш, гар тээш 317 ш, 23ш шуудан, 593 нийт зорчигч, 31, 28, ш нийт ачаа, 604 ш, гар тээш 468, 30ш шуудан байна. Нисэх буудлын ажилчид МХГ, Өрхийн эмнэлэг, Авиа компанийн ажилчдыг давхардсан тоогоор 241 удаа аюулгүй байдлын үзлэгт хамруулав.

Өдөр бүрийн бэлэн байдлын мэдээг цаг тухайд нь явуулж байв. Бүх тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийж ямар нэгэн сааталгүй ажилласан болно.

6-р сарын нислэгийн тоо:

№	Авиа компани	Агаарын хөлгийн маяг	Нислэгийн тоо
1	Аэро-Монголиа	ER 145	10
2	Хүннүү-Эйр	ATR-72 / ERJ160	8
Нийт			18

БНХАУ-д гарсан шинэ төрлийн коронавирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоол, 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны А/44 дүгээр тушаал, 2020 оны А/48 дугаар тушаал зэрэг улсын хэмжээнд болон зам тээврийн салбарт тусгайлан өгөгдсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг ханган ажиллах үүргийн дагуу 2020 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байна.